

## “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ”

(Түүхэн баримтын цуврал)

Монголын төмөр замын салбарт шинэ бүтээн байгуулалтууд эрчимжиж байгаа өнөө үед ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Кэмбрижийн их сургуулийн Археологи, антропологи тэнхимтэй хамтран Британий Академийн (British Academy) шугамаар Монголын төмөр зам, уул уурхайн геополитикийн чиглэлээр хамтарсан төслийг 2013 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Уг төслийн хүрээнд БНМАУ-ын төмөр замын хөгжлийн түүхэнд холбогдох түүхэн баримт бичгүүдийг эмхтгэн цуглуулж, олон нийтэд хүргэх үүднээс тус хүрээлэнгийн “Олон улс судлал” сэтгүүлийн Архивын сан хөмрөг буландаа Монголын төмөр замын түүхэнд холбогдох баримтуудаас он цагийн дарааллын дагуу цувралаар нийтэлж эхлэхээр тогтсон юм. Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт 100-аад жилийн өмнө байгуулсан Монгол Улсын анхны төмөр замын гэрээ болох Хаант Орос ба Богд хаант Монгол улсын хооронд 1914 онд байгуулсан Төмөр замын гэрээ, мөн Монгол улс дахь анхны нарийн төмөр зам болох “Эрээнцав-Баянтүмэний төмөр зам”-ыг байгуулах тухай БНМАУ ба ЗСБНХУ-ын хоорондын байгуулсан түүхэн гэрээ бичгүүдийг бүрэн эхээр тус тус нийтэлж байна.

Бэлтгэсэн: Р.Төрдалай /ОУСХ-гийн ЭША/

**МОНГОЛ УЛСЫН ХЯЗГААРЫН ДОТОР ТӨМӨР ЗАМ  
БАЙГУУЛАХ ЯВДЛЫГ ИХ ОРОСЫН ЗАСГИЙН  
ГАЗАРТАЙ ХЭЛЭЛЦСЭН ГЭРЭЭ\*  
(1914 ОН)**

Монгол газар худалдаа арилжаа бадарсан учир Монгол улсын төмөр замуудыг ойр бүхий төмөр замууд лугаа холбож бататгахыг чухал болгохуй дор ойр нь Сибирийн төмөр зам болох бөгөөд зохистой төмөр зам тавих явдлыг Монгол улсын Засгийн газар Их Орос улсын хаан эзний Засгийн газрууд найртайгаар хэлэлцэн тогтоосон нь:

Нэгдүгээр зүйл. Монгол улсын хязгаарын дотор төмөр зам байгуулах эрхийг Монгол улсын Засгийн газар үүрд хадгалахыг Орос улсын хаан эзний Засгийн газраас батлав.

Хоёрдугаар зүйл. Монгол улсын Засгийн газар Орос улсын хаан эзний Засгийн газрууд харилцан зөвлөж, Монгол, Орос хоёр улсад чухал хэрэглэгдэх эл тухайтай төмөр замуудыг үлэмжхэн ашиг тустай чиг ба дэс дараалан байгуулахыг хэлэлцэн тогтмой.

Гуравдугаар зүйл. Эдгээр замуудын аль нэгэн замыг урьтал болгож тогтоох аваас тэр тогтоосон төмөр зам байгуулахад Орос, Монгол хоёр засгийн хөрөнгө буюу эс бөгөөс энгийн хөрөнгөөр байгуулах алин боловч тухай дор Монгол улсын Засгийн газар, Их Орос улсын Засгийн газраас тусламж үзүүлмүй.

Дөрөвдүгээр зүйл. Орос улсын хязгаарын төмөр замууд лугаа холбох төмөр замыг хамт нийлүүлэн байгуулахад ямар янз холбогдох учир ба газар орон аливаа эрх ашгийн зүйлүүдийг Орос, Монгол хоёр Засгийн газар нэгэн адил нарийвчлан хэлэлцэн тогтоомой.

Тавдугаар зүйл. Монгол засгийн харьяат газрын хязгаарын дотор төмөр зам байгуулах эрх буй тул хойч өдөр Монгол Засгийн газраас өөрийн хөрөнгөөр тусгай төмөр зам байгуулах болбоос Орос Засгийн газар ер хамаарахгүй. Гагцхүү бусад хэн дор ч төмөр зам байгуулах эрх олгох ахул Монгол засгийн газраас айл бүхий Их Орос улс лугаа хэлэлцэж, Орос улсын ашиг ба цэргийн зүйл дор харштай болох эсэхийг зөвлөмүй.

Зургадугаар зүйл. Энэхүү гэрээ бичгийг Орос, Монгол үсгээр хавсран хошоод хувь бичиж, гарын үсэг зурж, тамга дараад нэгэн хувийг Монгол улс дор суугаа Оросын генеральной консул сайдын яамнаа хадгалж, үлдсэн нэгэн хувийг Монгол улсын Гадаад

хэргийг бүгд эрхлэн шийтгэх яамнаа хадгалмой.

Их Орос улсын хаан эзний Засгийн газраас эрх олгосноор Нийслэл хүрээнд суугаа элчин сайд бөгөөд Генеральной консул сайд действительный статский советник Миллер, Монгол улсын Засгийн газраас эрх олгосноор Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайд нанс билэгт гүн лам Дашжав, Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны тэргүүн сайд чин вангийн зэрэг түшээт чин ван Чагдаржав, Гадаадын Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэгч яамны дэд сайд хичээнгүй гүн Цэрэндорж

Олноо өргөгдсөний Дөрөвдүгээр он /1914 он/ найман сарын арван нэгэн. Хиагтийн газар тогтоов.

Архивын Ерөнхий Газрын <http://www.archives.gov.mn> цахим хуудаснаа АЕГ-ын Түүхийн Баримтын Төвийн архивч Т.Насанжаргалын бэлтгэн оруулсан “Монгол улсын хязгаарын дотор төмөр зам байгуулах явдлыг Их Оросын Засгийн Газартай хэлэлцсэн гэрээг сийрүүлсэн хуулга”-аас бичвэрлэн авч бэлтгэв.